



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/9/СТА-ТТЗ

Баянхонгор  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024      Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:              Б.Азбаяр

Утас: 99061429      Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
	2.1. Оршил .....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
	2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	9
	2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....	9
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	10
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл: .....	11
	2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13

---

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 9/165  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519316

E:\ajil\2019 он\СТА 2018\19. Bayan-Owoo ZD\4.Tailagnal\Баян-Овоо ТЭЗ гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Баян-Овоо сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

---

### **2.1. Оршил**

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Ж.Хатанбаатар-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 05-нд албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баян-Овоо сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баян-Овоо сумын Засаг дарга нь “Хүний хөгжил, уламжлалт ёс заншилаа дээдлэн дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, ялал жуулчлал хөгжсөн, эдийн засгийн хөгжлийг тогтворжуулж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан хөдөө аж ахуйн салбарын хөгжлөөр тэргүүлэгч сум болно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баян-Овоо сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж иргэдэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгож сумын нутаг дэвсгэрийн хэмжээнийхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах.

Баян-Овоо сумын Засаг даргын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 5 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Баян-Овоо сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	3	-	1	-
	Дүн	4	3	-	1	-

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баян-Овоо сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Овоо сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баян-Овоо сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Баян-Овоо сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баян-Овоо сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийжээ. Аудитаар нийт Баян-Овоо сумын ИТХ, ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв нь 2018 оны тайланг хугацаандаа илгээсэн байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баян-Овоо сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2237592.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 22375,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Баян-Овоо сумын Засаг даргын болон төвлөрүүлэн захирагчын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 6200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

### **2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

**Асуудал 1:** Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуултын баримтын бүрдэл хангалтгүй, ихэнх мөнгийг шагнал урамшилд болон нутгийн зөвлөлийн уулзалт, багуудын өдөрлөг гэх мэт үр ашиггүй зүйлд зарцуулсан.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн.

**Асуудал 2:** Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай үүссэн тооцоог нийлж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. 2018 оны эцэст авлага, өглөггүй тайлан гарсан боловч Засаг даргын нөөц хөрөнгөс сумын төвд баригдах цэцэрлэг, ахмадын сувилалын барилгын газрын хөрсний геологийн шинжилгээнд 1600,0 мянган төгрөг зарцуулж, авалгаар тусгаагүй.

**Шийдэл:** Санхүүгийн тайланд зарцуулсан.

### **2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд дараах алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гарлаа.

**Асуудал 1:** Сум хөгжүүлэх сангийн төлвөлөгөөг 80616.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

**Шийдэл:** Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баян-Овоо сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1446497.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1331786.6 мянган төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь 2018 онд улсын төсвөөс 868299.1 мянга, санхүүгийн дэмжлэгээр 242372.8 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 34660.7 мянган төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 92680.1 мянга, урьд оны үлдэгдэлээс 6338.1 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 3117.9 мянган төгрөгийг төсөвт байгууллагын болон орон нутгийн тусгай сангийн урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 84906,7 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 120020,4 мянган төгрөг ба гүйцэтгэлээр 124300,9 мянган төгрөгийн орлого төвлөрч 4280,5 мянган төгрөг буюу 103,6 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд хадгаламжийн хүүгийн орлого 2638,6 мянган төгрөг, Хүү, торгуулийн орлого 21292,5 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 896,3 мянган төгрөгөөр давсан ИОТХуудсаар орсон орлого 11999,9 мянга, Улсын тэмдэгтийн хураамж 26,6 мянга, нохойны албан татвар 300.0 мянга, ан амьтны агнуурын нөөцийн орлого 8220,4 төгрөгөөр тасарсан байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баян-Овоо сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 төрлийн зөвлөмж өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 93 хувь буюу 82216.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 7 хувь буюу 6200.0 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

№	Байгууллагын ангилал	Мянган төгрөг							
		Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Залруулга	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	1	80616.0	1	80616.0	1	80616.0
2	ТШЗ	1	6200.0	1	1600.0	2	7800.0	1	1600.0
	Дүн	1	6200.0	1	82216.0	2	88416.0	1	82216.0

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил	Мянган төгрөг										
			Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
2	ТШЗ	1	6200.0	-	-	-	-	1	6200.0	-	-	-	
	Дүн	1	6200.0	-	-	-	-	1	6200.0	-	-	-	

### 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	5	-	-	-	5
	Дүн	5	-	-	-	5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>193,506,464.40</b>	<b>267,636,763.37</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	10,532,709.37	89,404,519.09
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	10,532,709.37	89,404,519.09
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	10,532,709.37	89,404,519.09
31211	Төрийн сангийн харилцах	10,497,211.97	89,404,519.09
31213	Арилжааны банк дахь харилцах	35,497.40	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	153,348,740.03	99,222,322.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,649,928.14	307,572.09
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,600,401.89	10,642,000.00
3351	Байгууллагаас авах авлага	3,600,401.89	1,652,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	8,990,000.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	148,098,410.00	88,272,750.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	148,098,410.00	88,272,750.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	148,098,410.00	88,272,750.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,625,015.00	79,009,922.19
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,725,253.00	1,725,253.00
35110	Тусгай зориулалттай материал	1,725,253.00	1,725,253.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	27,899,762.00	77,284,669.19
35410	Бичиг хэргийн материал	2,632,960.00	3,751,820.00
35420	Аж ахуйн материал	3,490,350.00	7,689,684.00
35430	Сэлбэг хэрэгсэл	680,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	3,385,000.00	1,024,519.74
35450	Барилгын засварын материал	208,000.00	-
35460	Хүнсний материал	2,472,452.00	2,571,505.45
35470	Бусад хангамжийн материал	15,031,000.00	62,247,140.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,367,413,879.66</b>	<b>3,146,122,080.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,367,413,879.66	3,146,122,080.89
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,366,831,046.40	3,039,240,247.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,022,542,103.00	3,193,378,544.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,316,632,019.11)	(610,835,820.43)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	218,363,736.00	214,404,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(131,153,244.81)	(117,366,850.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	369,206,683.45	431,801,420.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(231,362,799.33)	(235,918,730.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	170,329,230.46	162,354,994.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(88,081,473.17)	(88,343,452.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	483,041,076.58	132,931,643.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(153,758,328.87)	(68,680,381.89)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	15,800,000.00	15,800,000.00
39217	Ном	8,536,082.20	9,714,082.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	582,833.26	106,881,833.22
39301	Програм хангамж	3,162,600.00	1,777,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,579,766.74)	(1,523,766.78)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	106,628,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,560,920,344.06</b>	<b>3,413,758,844.26</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,903,318.93</b>	<b>5,734,207.02</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,903,318.93	5,734,207.02
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,903,318.93	5,734,207.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	198,254.79	1,378,832.02

Баян-Овоо сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,099,719.00	105,300.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>3,605,345.14</b>	<b>4,250,075.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	3,585,345.14	4,250,075.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,556,017,025.13</b>	<b>3,408,024,637.24</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,556,017,025.13</b>	<b>3,408,024,637.24</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,261,892,245.71	1,368,520,245.71
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>759,244,352.56</b>	<b>787,417,361.64</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	790,960,520.78	760,868,186.82
51220	Тайлант үеийн үр дүн	(31,716,168.22)	26,549,174.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	534,880,426.86	1,252,087,029.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,560,920,344.06</b>	<b>3,413,758,844.26</b>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1848299262.63</b>	<b>2264141140.83</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>180204225.63</b>	<b>95273482.00</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>68183925.63</b>	<b>48000032.00</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>68183925.63</b>	<b>48000032.00</b>
110002	Үйл ажиллагааны орлого	68183925.63	48000032.00
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>1170000.00</b>	<b>1000000.00</b>
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	600000.00	
113002	Бууны албан татвар	570000.00	1000000.00
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>110850300.00</b>	<b>46273450.00</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>1640300.00</b>	<b>1473450.00</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1640300.00	1473450.00
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>109210000.00</b>	<b>44800000.00</b>
